

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**“Тэсийн илч” ХХК” -ийн 2025 оны санхүүгийн тайлан, тодруулгад
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан.**

Аудитын код: ХӨА-2026/021/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн захирал:
Д.Мягмарсүрэн
Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн аудитор:
Б.Пүрэвсүрэн
Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

дсдб: 03/16

№ 01/498

танай _____-ны № _____-т

“ТЭСИЙН ИЛЧ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ЭНХБАЯР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тэсийн илч” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Тэсийн илч” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах материаллаг зөрчил илэрсэн. Үүнд:

Оны эцэст 63,077.9 мянган төгрөгийн бараа материал, 2,882,755.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дансанд жилийн эцсийн тооллого хийгээгүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дүгээр зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1-т “өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах” зэрэг заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн ба зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 94,077.5 мянган төгрөгийн барилга байгууламж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 46,200.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 115,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Тэсийн илч” ХХК зорилтот түвшний 2025 оны төлөвлөгөөг 479,819.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 814,388.2 мянган төгрөгийн зардал гарган 334,568.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөн батлуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

“Тэсийн илч” ХХК нь хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үнэ тарифыг шинэчлэн тогтоогоогүй Хөвсгөл аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн 05/24 дүгээр тогтоолоор баталсан халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тарифыг ашиглаж байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,610,269.08	6,069,049.62
1.1.2	Дансны авлага	37,311,288.12	31,130,666.91
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	11,400,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	32,635,968.31	63,077,966.44
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	0.00	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	71,557,525.51	111,677,682.97
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,977,886,797.20	2,882,755,934.52
1.2.2	Биет бус хөрөнгө	18,768,000.00	18,614,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,996,654,797.20	2,901,369,934.52
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,068,212,322.70	3,013,047,617.49
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	299,228.50	48,167,487.69
2.1.1.2	Цалингийн өглөг	(0.00)	(0.00)
2.1.1.3	Татварын өр	15,186,012.77	38,393,142.46
2.1.1.4	НДШ - ийн өглөг	7,618,356.98	29,348,651.59
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	23,103,598.25	115,909,281.74
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	23,103,598.25	115,909,281.74
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	3,632,203,450.00	3,632,203,450.00
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- Хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	256,113,021.51	256,113,021.51
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	953,988,371.06	1,209,265,951.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,797,196,118.11)	(1,817,823,984.36)
2.3.10		0.00	(382,620,102.46)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,045,108,724.46	2,897,138,335.75
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	3,068,212,322.70	3,013,047,617.49

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
31	Борлуулалтын орлого (цэвэр)	410,279,702.04	458,514,879.61
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	647,277,258.30	761,528,993.41
3	Нийт ашиг (алдагдал)	(236,997,556.26)	(303,014,113.80)
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	381,000.00	11,510,235.69
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	60,772,322.00	89,913,997.00
11	Санхүүгийн зардал	57,000.00	99,709.02
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	284,000.00	1,102,518.33
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(297,729,878.26)	(382,627,102.46)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(297,729,878.26)	(382,627,102.46)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(297,729,878.26)	(382,627,102.46)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(297,729,878.26)	(382,627,102.46)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	433,831,790.54	512,805,000.17
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	432,484,128.80	512,470,000.17
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтын орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	1,347,661.74	335,000.00
1.2	Мөнгөн зарлага (-)	460,728,572.85	506,353,309.87
	Ажиллагчдад төлсөн	193,681,293.00	264,774,109.77
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	56,728,252.77	48,086,220.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	38,522,717.44	17,387,185.00

	Ашиглалтын зардалд төлсөн	67,288,339.55	103,369,252.38
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	35,411,683.00	52,425,950.00
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	21,424,244.32	11,871,950.70
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
	Бусад мөнгөн зарлага	47,380,442.77	8,438,642.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,605,182.31)	6,451,690.30
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	507,090.24
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	500,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	7,090.24
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,278,000.00	2,500,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,278,000.00	2,500,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,278,000.00)	(1,992,909.76)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахал төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(29,883,182.31)	4,458,780.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,088,126.07	1,610,269.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,204,943.76	6,069,049.62

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	3,632,203,450.00	211,418,021.51	95,124,931.00	(251,295,485.29)	3,687,450,917.22
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(181,517,211.85)	(181,517,211.85)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	63,528,591.58	(553,540,627.53)	(490,012,035.95)
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	41,152,800.00	0.00	0.00	41,152,800.00
2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	3,632,203,450.00	252,570,821.51	158,653,522.58	(986,353,324.67)	3,057,074,469.42
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(382,620,102.46)	(382,620,102.46)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	255,277,580.00	0.00	255,277,580.00
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	3,632,203,450.00	252,570,821.51	413,931,102.58	(1,368,973,427.13)	2,929,731,946.96

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	2025		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1.0	Ажилчдийн тоо	24.0	24.0	1.00	
	Халаалтын орлого	445,085.2	421,636.5	23,448.70	94.73
	Бохир/ цэвэр усны орлого	23,874.1	23,889.6	(15.50)	100.06
	Түрээсийн орлого	1,260.0	1,260.0	-	100.00
	Цэвэр усны орлого	9,600.0	11,587.2	(1,987.20)	120.70
2.0	Нийт орлого	479,819.3	458,373.3	21,446.00	95.53
	Үндсэн цалин	270,054.0	269,307.0	747.00	99.72
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,500.0	9,985.8	(3,485.80)	153.63
	НДШЗардал	36,457.3	36,356.4	100.86	99.72
	Гэрэл цахилгаан	56,000.0	89,947.2	(33,947.20)	160.62
	Түлш халаалт/нүүрс/	24,000.0	4,961.8	19,038.20	20.67
	Бичиг хэрэг	600.0	574.2	25.80	95.70

	Тээвэр шатахуун	15,000.0	21,285.5	(6,285.50)	141.90
	Нүүрс тээвэр	24,000.0	34,891.0	(10,891.00)	145.38
	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,000.0	933.9	66.10	93.39
	Хог хягдал зайлуулах зардал/Үнс нурам/	2,500.0	2,500.0	-	100.00
	БҮТЭЗ	300.0	187.8	112.20	62.60
	Хоол хүнс	6,000.0	5,344.3	655.70	89.07
	Хөдөлмөр хамгаалал	7,000.0	6,612.3	387.70	94.46
	Урсгал засвар	1,000.0	1,237.6	(237.60)	123.76
	Сэлбэг хэрэгсэл	15,000.0	14,176.4	823.60	94.51
	Дотоод албан томилолт	1,000.0	1,334.2	(334.20)	133.42
	Аудитын төлбөр	1,800.0	-	1,800.00	-
	Үйлдвэрийн зориулалтаар ус ашигласны төлбөр	400.0	457.5	(57.50)	114.38
	Усны шинжилгээний төлбөр	200.0	257.0	(57.00)	128.50
	ЭХЗЗ-ийн үйлчилгээний хөлс	1,600.0	1,600.0	-	100.00
	ҮХХ-ийн албан татвар	459.5	459.5	-	100.00
	Газрын төлбөр	80.0	80.0	-	100.00
	Программын лиценз Архив	500.0	473.0	27.00	94.60
	Хог хаягдалын хураамж	50.0	50.0	-	100.00
	Үйлчилгээний хөлс	1,000.0	1,000.0	-	100.00
	Банкны шимтгэл	100.0	94.9	5.10	94.90
	Гамшигаас хамгаалах/ БЭЗ/	1,000.0	1,000.0	-	100.00
	ЭХШ-ийн зардал	334,612.3	334,612.8	(0.50)	100.00
	ТУЗ-ийн зардал	6,175.1	1,872.7	4,302.40	30.33
3.0	Нийт зардал	814,388.2	824,539.0	(10,150.85)	101.25
4.0	Ашиг алдагдал	(334,568.9)	(366,165.7)	31,596.84	109.44

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,080,058.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,037,676.4 мянган төгрөгийн 4 зөрчилд зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 42,382.2 мянган төгрөгийн 4 зөрчилд компанийн үр ашгийг нэмэгдүүлэх болон бусад зөвлөмжийг тус тус өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 878,767.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй учир “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно.

Аудитын явцад залруулах боломжгүй алдаа зөрчлүүд тул цаашид анхаарч ажиллах зөвлөмж шаардлагыг хүргүүлж, залруулах алдаа байхгүй болно.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

3.2 Албан шаардлага.

Аудитаар 3,037,676.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага тогтоосон. Үүнд:

1. Тайлангийн хугацааны эцэст 48 011.1 мянган төгрөгийн авлага, 2 278.4 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны

- баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 35 000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 24 032.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй ДСК-150 Дизель станцыг ТУЗ-ын болон эрх бүхий байгууллагын шийдвэргүй 10 000.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь Төрийн өмчийн болон орон нутгийн тухай хуулийн 16 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 2-т “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй” , Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ”, 1.6-д “Хөрөнгө худалдах, хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ” заалтууд зөрчсөн болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
 3. Компанийн ТУЗ-өөс 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тооцоо, судалгаа хийгдэхгүй, үр дүнг тооцон дүн шинжилгээ хийж компанийн ашигт ажиллагааг бодитой гаргаагүй элэгдлийн зардлын хэмжээгээр 334 568.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар батлуулж, тайлангийн хугацааны элэгдлийн зардлыг тооцохгүйгээр ч 31 552.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах,” Засгийн газрын 2020 оны 217 тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” -ын 2.2-т “Төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна” гэсэн заалтууд зөрчигдөж байна.
 4. Тайлангийн хугацааны эцэст 63 077.9 мянган төгрөгийн бараа материал, 2 882 755.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дансанд тооллого хийгдэж тооцоо бодоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ” 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дүгээр зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:” 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/, 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Халуун усны барилгыг 2022 оны гэрээгээр ашиглалтын зардал, эдийн засгийн үр ашгийг тооцохгүй жилийн 1 250.0 мянган төгрөгөөр хувь хүнд түрээслэхээр тухайн жилийн орлогын төлөвлөгөөнд батлуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн бүртгэлийн зарчим 5.1.4-т "үнэн зөв байх", 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", Засгийн газрын 2020 оны 217 тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" 2.4.4-д "Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх", Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2020 оны 03 тогтоолоор шинчлэгдсэн орон нутгийн эд хөрөнгийг түрээслэх журмын 1.3 Орон нутгийн онцлогийг харгалазан түрээслэгч ашиглалтын зардлаа өөрөө төлсөн тохиолдолд сумдад байршилтай түрээслүүлж буй байрны түрээсийн төлбөрийн жишиг үнийг 60 хувиар бууруулан тогтоож болно" гэсэн заалтуудыг баримталж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Үүссэн өр төлбөрийг барагдуулах, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллан үр ашиггүй зардал гаргахгүй байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Нүүрсний 31 437.2 мянган төгрөгийн худалдан авалтын баримтыг харилцагч компаниуд шивээгүй санхүүгийн тайланд анхан шатны баримтгүй гүйлгээ тусгагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; Нэмэгдсэн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17.2-т "худалдан авалт цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн байх", 15.17.3-д "татварын албаны шаардлагад нийцсэн цахим төлбөрийн баримт авсан байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн байх

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: “Шилэн дансанд 6 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Өгсөн зөвлөмж: Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

4. Цалингын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд 3 ажилтаны 2 772.6 мянган төгрөгийн цалин дутуу, 3 ажилтны 2 334.7 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан. Мөн НД тайлангийн цалин цалингийн хүснэгтээс 4 587.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байа. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102.1.5.цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор,

төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Завсрын аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Халуун усны барилгыг хувь хүнд хөрөнгийг ашиглахад гарах ашиглалтын зардлыг тооцохгүй, эдийн засгийн үр ашиггүй жилийн 1 250.0 мянган төгрөгөөр түрээслүүлж байна.	1	1,250.0					1	1,250.0		
Үндсэн хөрөнгийн дансанд биетээр тооллого хийхэд 29 300.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй Кама хогны машин байхгүй сумын тамгын газарт ашиглагдаж байгаа, 16 200.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй Оргил халуун усны барилгад хими цэвэрлэгээний үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа боловч тухайн компани ашигладаггүй сумын тамгын газар ашиглаж байна.	1	45,500.2			1	45,500.2				
Компанийн ТУЗ-ын гишүүдийн цалин, урамшуулал тогтоосон болон олгох шийдвэргүй бизнес төлөвлөгөөнд тусган батлуулж, нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутгаагүй 1 194.7 мянган төгрөгийн цалин, урамшуулал олгосон байна.	1	1,194.7	1	1,194.7						
Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын хэмжээгээр 334 568.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж батлуулсан байна	1	334,569.9			1	334,569.9				
Тээврийн хэрэгслийн дансанд 132 995.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 30,210.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй компанийн дансанд бүртгэлтэй 4 ширхэг машин тээврийн хэрэгслийн гэрчилгээ байхгүй байна.	1	5,675.9							1	5,675.9
Ашиглалтын хугацаа дууссан 1 ширхэг 64 642.3 мянган төгрөгийн барилга 10 нэр төрлийн 16 ширхэг 2 518.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 13 нэр төрлийн 16 ширхэг 22 932.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2 ширхэг 64 300.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл ашиглагдаж байна.	1	154,392.3					1	154,392.3		
Нийгмийн даатгалын тайланд 3 ажилтаны 2 772.6 мянган төгрөгийн цалин дутуу, 3 ажилтаны 2 334.7 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан	1	9,695.0							1	9,695.0
Шилэн дансанд 3 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого томиссын тушаал, эмчийн үзлэгт хамрагдсан үзлэгийн тушаал, 3 239.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актласан тушаал зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна.	1	3,239.6			1	3,239.6				
Үндсэн хөрөнгийн дансанд сорил гүйцэтгэхэд хөрөнгийн бүртгэл хангалтгүй эд хариуцагчийн карт байхгүй, хагас жилийн тооллого хийгдээгүй, биетээр байгаа хөрөнгө санхүүгийн тайлангийн хөрөнгийн бүртгэлтэй тохирохгүй, хөрөнгийн ангилал буруу, биетээр ашиглагдаж байгаа хөрөнгө бүртгэлд	1	-								

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

байхгүй, ашиглагдахгүй хөрөнгийг актлах шийдвэр гаргуулаагүй зэрэг зөрчилтэй байна.											
Хагас жилээр 40 801.0 мянган төгрөгийн авлага, 23 603.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	64,404.0					1	64,404.0			
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийгдэж байгаа ч тендерийг харьцуулалтын болон шууд худалдан авах аргыг ашигласан гэх боловч бичиг хэргийн материалын 15 000.0 мянган төгрөгийн тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтлээгүй, хэлэлцээ хийх урилга хүргүүлээгүй тендерийн материал шаардлага хангахгүй байна.	1	15,000.0					1	15,000.0			
Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 35 000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 24 032.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй ашиглагдахгүй эвдэрсэн гэх ДСК-150 Дизель станцыг компанийн бүх гишүүдийн хурлаар зарж борлуулах хурлын тэмдэглэл хөтлөн 10 000.0 сая төгрөгөөр тушаал, шийдвэргүй зарж борлуулсан байна.	1	10,000.0				1	10,000.0				
Үндсэн хөрөнгийн дансанд сорил гүйцэтгэхэд ашиглагддаггүй эвдэрсэн 40 000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 14 666.6 мянган төгрөгийн Хогны машин, 60 000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 25 457.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Уурын зуухны тогоо 50 900.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 46 658.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 100 дизель генератор зэрэг бүртгэлтэй үр ашиггүй элэгдлийн зардал өсөж алдагдалтай ажиллахад нөлөөлж буй хөрөнгүүд байна	1	86,782.5				1	86,782.5				
Тавилга эд хогжлийн дансанд 12 864.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэсэн	1	12,864.3					1	12,864.3			
ТУЗ-ийн гишүүд нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг үр ашигтай зохион байгуулах талаар бодитой санал, санаачилга гаргаж ажиллаагүй байна.	1	-					1	-			
Бараа материалын худалдан авалттай холбоотой 1 075.0 мянган төгрөгийн гүйлгээ нь цахим и-баримтгүй байна.	1	1,075.0	1	1,075.0							
Бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийхэд бүртгэлээр хүнсний материалын үлдэгдэлд байгаа 1 737,9 мянган төгрөгийн үхэр адууны мах байхгүй байна.	1	1,737.9	1	1,737.9							
Нийт дүн	16	747,381.5	3	4,007.6	5	480,092.1	6	247,910.6	2	15,371.0	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлангийн хугацааны эцэст 48 011.1 мянган төгрөгийн авлага, 2 278.4 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	50,289.6			1	50,289.6		

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Халуун усны барилгыг 2022 оны гэрээгээр ашиглалтын зардал, эдийн засгийн үр ашгийг тооцохгүй жилийн 1 250.0 мянган төгрөгөөр хувь хүнд түрээслэхээр тухайн жилийн орлогын төлөвлөгөөнд батлуулсан байна.	1	1,250.0					1	1,250.0
Нүүрсний 31 437.2 мянган төгрөгийн худалдан авалтын баримтыг харилцагч компаниуд шивээгүй санхүүгийн тайланд анхан шатны баримтгүй гүйлгээ тусгагдсан байна.	1	31,437.2					1	31,437.2
Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 35 000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 24 032.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй ДСК-150 Дизель станцыг ТУЗ-ын болон эрх бүхий байгууллагын шийдвэргүй 10 000.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна.	1	10,000.0			1	10,000.0		
Компанийн ТУЗ-өөс 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тооцоо, судалгаа хийгдэхгүй, үр дүнг тооцон дүн шинжилгээ хийж компанийн ашигт ажиллагааг бодитой гаргаагүй элэгдлийн зардлын хэмжээгээр 334 568.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар батлуулж, тайлангийн хугацааны элэгдлийн зардлыг тооцохгүйгээр 31 552.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	31,552.9			1	31,552.9		
Нийгмийн даатгалын тайланд 3 ажилтны 2 772.6 мянган төгрөгийн цалин дутуу, 3 ажилтны 2 334.7 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан. Мөн НД тайлангийн цалин цалингийн хүснэгтээс 4 587.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.	1	9,695.0					1	9,695.0
Тайлангийн хугацааны эцэст 63 077.9 мянган төгрөгийн бараа материал, 2 882 755.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дансанд тооллого хийгдэж тооцоо бодоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	2,945,833.9			1	2,945,833.9		
Дүн	7	42,655.0			4	3,037,676.4	3	42,382.2

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Тоо	Дүн	Тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансанд 6 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна.	1	-	-	-			1	-
Нийт дүн	1	-	-	-			1	-

